



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А/387

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Б.Хоролбат	Худалдан авах ажиллагааны хэлтсийн менежер
Нарийн бичгийн дарга:	П.Хатанбаатар	Худалдан авах ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Гишүүд:	М.Эрдэнэсүх	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Жавхлан	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	С.Чинзориг	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Б.Хоролбат/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /П.Хатанбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА / Л.БЯМБАСҮРЭН